



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/56

Жаргалтхаан

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 84 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 2, 5 дугаар хавсралт, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024 оны 128 дугаар тогтоолын 3, 6, 9, 10, 11, 12 дүгээр хавсралт, "Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 6 дугаар хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны 02 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн албаны дарга, Багийн Засаг дарга нарын үндсэн цалинг хавсралтад заасны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосугай.

2.Дээрх албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл олгох хувь хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Албан хаагчдын үндсэн цалинг хавсралтад зааснаар тооцон, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийн нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч 3.Жанчивт зөвшөөрсүгэй.

232431131

2.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Б/19 дугаартай захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

ХАМГААХ

Засаг даргын 2024 оны 04 сарын
10. өдрийн 15.6 тоот захирамжийн
...7 дугаар хавсралт

Цалин шинэчлэн тогтоосон жагсаалт

№	Албан хаагчдын нэрс	Албан тушаал	Зэрэглэл	Үндсэн цалин
1	С.Ганбат	Засаг даргын орлогч	УТ	1,870,000
2	С.Мөнхдэлгэр	Засаг даргын Тамгын газрын дарга	ТЗ-5	1,757,000
3	Н.Түвшинжаргал	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч	ТҮЭМ-6	1,471,000
4	Ж.Ариунгэрэл	Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	ТҮСБ-5	1,544,000
5	Д.Энхболд	Гичгэнэ багийн Засаг дарга	УТ	1,375,000
6	Э.Аранжил	Баянцогт багийн Засаг дарга	УТ	1,375,000
7	М.Өсөхжаргал	Баян-Эрдэнэ багийн Засаг дарга	УТ	1,375,000
8	Б.Мэндбаяр	Чулуут багийн Засаг дарга	УТ	1,375,000
9	Б.Жаргал	Төвийн багийн Засаг дарга	УТ	1,375,000
10	Э.Эрдэнэхүү	Санхүүгийн албаны дарга	ТЗ-7	1,452,000

Засаг даргын 2024 оны 07 сарын
10 өдрийн 113 тоот захирамжийн
...2 дугаар хавсралт

Орон нутагт ажилласны нэмэгдэл олгох жагсаалт

№	Албан хаагчдын нэрс	Албан тушаал	Үндсэн цалин	Орон нутагт ажилласны нэмэгдэл олгох хувь хэмжээ
1	С.Ганбат	Засаг даргын орлогч	1,870,000	40%
2	С.Мөнхдэлгэр	Засаг даргын Тамгын газрын дарга	1,757,000	60%
3	Д.Энхболд	Гичгэнэ багийн Засаг дарга	1,375,000	40%
4	Э.Аранжил	Баянцогт багийн Засаг дарга	1,375,000	40%
5	М.Өсөхжаргал	Баян-Эрдэнэ багийн Засаг дарга	1,375,000	40%
6	Б.Мэндбаяр	Чулуут багийн Засаг дарга	1,375,000	40%
7	Б.Жаргал	Төвийн багийн Засаг дарга	1,375,000	40%
8	Э.Эрдэнэхүү	Санхүүгийн албаны дарга	1,452,000	60%